



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/855

Булган сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд залуучуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, цанын спортыг бүх нийтийн спорт болгон хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Г.Баатарын нэрэмжит өсвөр үеийн “Цанын” улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Жаргалсайхан – (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: П.Нөхөрлөлбаяр – (Булган сумын Засаг дарга)

Г.Ганбаяр – (Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа)

Ш.Баасандорж (Онцгой байдлын газрын дарга)

Х.Батхишиг – (Биеийн тамир, спортын газрын дарга)

Ж.Ганболд – (Боловсрол шинжлэх ухааны газрын дарга)

Г.Алдармөнх-(Соёл, урлагийн газрын дарга)

П.Оюунцэцэг – (Эрүүл мэндийн газрын дарга)

О.Ууганчимэг – (Хөгжимт жүжгийн театрын дарга)

Д.Баттуяа – (Булган хангай мэргэжил сургалт

үйлдвэрлэлийн төвийн захирал)

Н.Пүрэвсайхан – (Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт

үйлдвэрлэлийн төвийн захирал)

Л.Наранбат (Спортын дунд сургуулийн захирал)

Л.Оргил – (Эрдэнэт, Булган цахилгаан түгээх сүлжээ

ТӨХК-ний захирал)

Нарийн бичгийн дарга: Ё.Хулан – аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг
ажлын хэсгийн ахлагч (Д.Жаргалсайхан)-д даалгасугай.

